



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/371

Ховд

“Цэргийн бэлтгэл” сургалтад хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-а, 29.2, 30.1.6, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.1, 17.1.6, Дайчилгааны тухай хуулийн 28.1.2, Цэргийн албаны тухай хуулийн 33.10 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын хавсралтын 4.1.1, 4.1.5 дахь заалт, Батлан хамгаалахын сайд Ховд аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээ, Батлан хамгаалахын сайдын 2019 оны 1а/1878 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны сургалт, семинарын нэгдсэн төлөвлөгөө, Батлан хамгаалах яамны болон Цэргийн штабын 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Баян-Өлгий аймагт 2019 оны 06 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд явагдах Баруун бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Цэргийн штабын офицерууд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг хамруулсугай.

2. Сургалтад хамруулахад шаардагдах 3.466.940 /гурван сая дөрвөн зуун жаран зургаан мянга есөн зуун дөчин/ төгрөгийн тооцоог хавсралтаар баталж цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Сургалтад хамрагдах бүрэлдэхүүний тээвэрлэлтийн болон бусад аюулгүйн ажиллагааг хангуулах, сахилга, дэг журам, төрийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Цэргийн штабын дарга /дэд хурандаа Б.Ганхуяг/ нарт даалгасугай.

02 01953

Zax A/371 Ch


4. Сургалтад хамруулсан тухай тайлан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт нь хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /дэд хурандаа Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар
сарын 14-ний өдрийн А/371 дүгээр захирамжийн
хавсралт



Баруун бүсийн аймгуудын сумын Засаг даргын
Тамгын газрын дарга нарын сургалтад оролцоход
шаардагдах төсвийн тооцоо

Шатахууны тооцоо

№	Авто машины улсын дугаар	нийт явах км	Зарцуулах ШТМ			
			100 км-т	нэгжийн үнэ	литрээр	төгрөгөөр
1	35-50ХОУ	1010	0.18	2555	181.8	464499
2	10-09ХОУ	1010	0.18	2195	181.8	399051
3	95-10ХОУ	1010	0.2	2195	202	443390
4	дүн				565.6	1306940
Хүндэтгэлийн арга хэмжээ						
д/д	материалын нэр		тоо	нэг бүрийн үнэ		нийт үнэ
1	Аймгууд болон бусад		2	120000		240000
	бүрэлдэхүүнд өгөх		3	100000		300000
	дурсгалын зүйл		4	30000		120000
2	Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн ангид алба хааж буй нутгийн хугацаат цэргийн алба хаагчидтай уулзалт явуулах арга хэмжээ, гарын бэлэг		100	15000		1500000
3	дүн					2160000
Нийт дүн			/4+3/			3466940

-оОо-